



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/656

Булган сум

Эрх олгох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ургац тээврийн авто зам засварын ажилд зориулан Сэлэнгэ сумын Засаг дарга (Б.Ууганбаяр)-д 10,000,000 (арван сая) төгрөг, Тэшиг сумын Засаг дарга (Ж.Гансүх)-д 40,000,000 (дөчин сая) төгрөг тус тус захиран зарцуулах эрхийг олгосугай.

2. Ургац тээврийн авто зам засварын ажилд зарцуулах эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Сэлэнгэ, Тэшиг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд батлагдсан "Ургац тээврийн авто замын засвар" зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ